

Инноваци гэж юу вэ

Мон-Х Инновацийн
хөтөлбөр



Инноваци



“Аливаа зүйлийг илүү дээр хийх арга ямагт байдаг. Түүнийг ол !”
Томас Эдисон.

Инноваци гэж юу вэ ?

- Хэн нэгний аль хэдийн зохион бүтээсэн зүйлийг сайжруулах, ашиг тусыг нь нэмэгдүүлэх өөрчлөлтийг хийх үйл явц
- Мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл явц.
- Ямар нэгэн шинэлэг зүйлийг сэдэж, үр дүнд хүрэхийн тулд хийж буй өөрчлөлт, шинэчлэлт
- Шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдлийг Инноваци гэнэ; (Инновацийн тухай хуулийн 3.1.1)

Инновацийн соёл (Innovation culture)

Шинэ шийдэл, эдийн засгийн төрөлжилтийг бий болгоход чиглэсэн, хувийн хөрөнгө оруулалт, оюуны потенциалыг идэвхтэй оролцуулсан байнгын эрэл хайгуул, үүнтэй холбоотойгоор үүсэх харилцааны хэм хэмжээ.

НЭЭЛТ



Laser




ИННОВАЦИ



Инноваци




Инноваци



Шумпетерийн инновацийн ангилал

1. **Бүтээгдэхүүний инноваци** (Product innovation):
Бүтээгдэхүүний нэр төрөл, чанарын хүрээнд хийсэн шинэчлэл.
2. **Процессийн инноваци** (Process innovation): Нэвтрүүлсэн үйлдвэрлэлийн шинэ арга.
3. **Бизнес загварын инноваци** (Business model innovation):
Шинэ зах зээл нээх болон зах зээлд шинээр нэвтрэх.
4. **Нийлүүлэлтийн инноваци** (Supply innovation): Түүхий эд, материалын шинэ эх үүсвэр нээх, эсвэл байгаа эх үүсвэрийг шинээр ашиглах.
5. **Зохион байгуулалтын инноваци** (Organisational innovation):
Шинээр үйлдвэр байгуулах.


Инновацийн 4 хэлбэр



Хувьсгалт инноваци (Disruptive)



Эрс инноваци (Radical)



810027048

Нэгдмэл инноваци (Architectural)



Өсөн нэмэгдэх инноваци (Incremental)



Зурсхийж орж ирдэг санаа биш



Инноваци бол
эврика момент
биш!



58 79 457

58 79

58 79 УБЛ

Баярлалаа

2022 он

Оюуны өмч

- Зохиогчийн эрх
- Аж үйлдвэрийн өмч
 - Патент
 - Шинэ бүтээл
 - Бүтээгдэхүүний загвар
 - Ашигтай загварын гэрчилгээ
 - Ашигтай загвар

Зохиогчийн эрх

- **6 дугаар зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх**
- Хэвлэх6.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх нь тухайн бүтээлийг бодитойгоор туурвиж, бодит хэлбэрт орсон үеэс үүснэ.
- 6.2.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх үүсэх, түүнийг хэрэгжүүлэхэд бүртгэл шаардахгүй.
- 6.3.Зохиогч сайн дурын үндсэн дээр өөрийн бүтээлийн мэдээллийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж болно.
- 6.4.Зохиогч өөрийн бүтээлийн зохиогч мөн болохоо нотлох үүрэг хүлээнэ.

Аж үйлдвэрийн өмч

- 7.1.Аж үйлдвэрийн өмчийн эрхэд дараах зүйл хамаарна:
- 7.1.1.шинэ бүтээл;
- 7.1.2.ашигтай загвар;
- 7.1.3.бүтээгдэхүүний загвар;
- 7.1.4.барааны тэмдэг;
- 7.1.5.газар зүйн заалт.

Барааны тэмдэг ба газар зүйн заалт

- 3.1.1."барааны тэмдэг" гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг;
- 3.1.2."хамтын тэмдэг" гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан хуулийн этгээдийн нэгдсэн хяналтын доор түүний гишүүд ашиглах барааны тэмдгийг;
- */Энэ заалтыг 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*
- 3.1.3."гэрчлэх тэмдэг" гэж тухайн бараа, үйлчилгээний чанар, үйлдвэрлэх арга, бусад онцлог шинж чанарыг эрх бүхий байгууллага гэрчлэн бусад этгээдэд ашиглуулах барааны тэмдгийг;
- 3.1.4."газар зүйн заалт" гэж тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн нэрийг;

Газар зүйн заалт

- 22.1.Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний тодорхойлолтод дараах зүйлийг тусгана:
- 22.1.1.бараа бүтээгдэхүүний чанар, онцлог шинж чанар нь тухайн газар нутагтай хэрхэн холбогдож байгаа тухай мэдээлэл;
- 22.1.2.газар зүйн заалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний хими, физик, микробиологи, бүтцийн шинж чанарын тухай мэдээлэл;
- 22.1.3.газар зүйн заалтад хамаарах газар зүйн бүсийг тодорхой заах;
- 22.1.4.гарал үүсэл, хүний болон байгалийн хүчин зүйл, нутаг дэвсгэрийн онцлогтой хэрхэн холбогдож тухайн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг талаарх тайлбар, мэдээлэл;
- 22.1.5.газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүн тухайн газар зүйн заалтын шинж чанарыг бүрэн агуулж байгаа эсэхийг тодорхойлох чанарын дотоод болон хөндлөнгийн хяналт хийх байгууллагын тухай мэдээлэл.
- 22.2.Энэ хуулийн 22.1.5-д заасан газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний чанарын дотоод хяналтыг газар зүйн заалт хэрэглэгч нэгдэл, холбоо, байгууллага хэрэгжүүлнэ.
- 22.3.Энэ хуулийн 22.1.5-д заасан газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний хөндлөнгийн хяналтыг аймаг, нийслэлийн чанарын хяналтын лаборатори болон чанарын хяналт тавих эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.
- 22.4.Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний чанарын хяналтын үр дүн нь энэ хуулийн 21.6.2-т заасан дүгнэлтэд тодорхойлсон шинж чанартай тохирч байвал тухайн бараа, бүтээгдэхүүнийг газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүнд тооцно.